



МОНГОЛ УЛС  
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Зарим шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн  
сул орон тоонд сонгон шалгаруулалт  
зарлах тухай

Шүүхийн захиргааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.11, 18.4, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, Шүүгчийг сонгон шалгаруулах журмын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Анхан болон давж заалдах шатны зарим шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн хавсралтад заасан сул орон тоонд сонгон шалгаруулалт зарласугай.

2. Шүүгчийн сонгон шалгаруулалтад оролцох нэр дэвшигчийн материал хүлээн авах ажиллагааг 2017 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 09 цаг 00 минутаас 01 дүгээр сарын 27-ны өдрийн 17 цаг 00 минут хүртэлх хугацаанд зохион байгуулахыг Шүүхийн мэргэшлийн хорооны ажлын алба /Н.Мөнхзул/-д үүрэг болгосугай.

3. Нэр дэвшигчдээс шалгалт авах, үнэлгээ өгөх ажиллагааг 2017 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс 02 дугаар сарын 27-ны өдрийг хүртэлх хугацаанд хэрэгжүүлэхийг Шүүхийн мэргэшлийн хороонд даалгасугай.

ДАРГА



Н. ЛҮНДЭНДОРЖ

**Анхан болон давж заалдах шатны зарим шүүхийн шүүгч,  
Ерөнхий шүүгчийн сонгон шалгаруулалт  
зарлах сул орон тоо**

УХА0052 1701517

№	Шүүхийн нэр, албан тушаал	Орон тоо
1	Говьсүмбэр аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
2	Сүхбаатар аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
3	Увс аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
4	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
5	Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
6	Баян-Өлгий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
7	Говьсүмбэр аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
8	Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
9	Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
10	Дорноговь аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
11	Дорнод аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
12	Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
13	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч	1
14	Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
15	Ховд аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч	1
16	Баянхонгор аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч (Эрүүгийн)	1

17	Сүхбаатар аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч (Эрүүгийн)	1
18	Увс аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч (Иргэний)	1
19	Дорнод аймаг дахь Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч (Эрүүгийн)	1
20	Ховд аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч	1
21	Дархан-Уул аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч	1
<b>Нийт</b>		<b>21</b>

-oOo-